



# БАЙГУУЛЛАГЫН 2020 ОНЫ БҮТЭН ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Байгууллагын нэр: **Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар**

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

НМХГ	Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар
БОГУУХХ	Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтэс
ДБХХ	Дэд бүтцийн хяналтын хэлтэс
ХНХХХ	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал, хяналтын хэлтэс
ХАБХААХХ	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн хяналтын хэлтэс
ЦЦАБХХ	Цөмийн болон цацрагийн аюулгүй байдлын хяналтын хэлтэс
ЭМБСХХ	Эрүүл мэнд, боловсрол, соёлын хяналтын хэлтэс
ЭИХХЦХХ	Экспорт, импорт, хилийн хорио цээрийн хяналтын хэлтэс
ЭУТХ	Эрсдэлийн удирдлага, төлөвлөлтийн хэлтэс
ТЛ	Төв лаборатори
МУТХҮБ	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал
ТХШТХ	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
МУЗГ-2016-2020 ОНЫ ҮАМХ	Монгол Засгийн засгын газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
АЭҮАТ	Авилгын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө
МУЭЗНХҮЧ	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл
НЗДБУБХЗ-2016- 2020 ОНЫ ҮАМХ	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр
НЭЗН 2020 ОНД ХҮЧ	Нийслэлийн эдийн засаг нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл
МХБ 2018-2020 ОНЫ ДХТ	Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөө
МХБЭУС	Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратеги
МХШЕШС	Мэргэжлийн хяналт шалгалтын ерөнхий шаардлага, стандарт



**НЭГДҮГЭЭР ХЭСЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ  
ТУСГАГДСАНЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ**

№	Үндсэн чиг үүрэг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Гүйцэтгэлийн үнэлгээ				Дундаж хувь
				.....%	.....%	.....%	.....%	
1	Мэргэжлийн хяналт шалгалт	4	26					
<b>Нийт</b>		<b>4</b>	<b>26</b>					

№	Стратеги төлөвлөгөө & Бодлогын баримт бичиг	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо
1	Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030	-	-
2	Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	1	9
3	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх 2020 оны үндсэн чиглэл	1	1
4	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр	1	8
5	Нийслэлийн эдийн засаг нийгмийн 2020 онд хөгжүүлэх үндсэн чиглэл	1	9
6	Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөө	51	81
7	Мэргэжлийн хяналтын байгууллагын эрсдэлийн удирдлагын стратеги	4	4
<b>Нийт</b>		<b>59</b>	<b>112</b>

**НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

**1.1. Мэргэжлийн хяналт шалгалт**

**Гүйцэтгэлийн зорилт №1.1.1 Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, хяналтын үйл ажиллагааны үр дүн, бүтээмжийг дээшлүүлнэ.**

№1.1.1.1	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.1-р арга хэмжээ: <b>Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, эрсдэлийн төлөв байдлын талаар олон нийтийг мэдээллээр хангах</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	ТХШТХ-ийн 5 <sup>д</sup> , Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны Дунд хугацааны төлөвлөгөө” 10 дугаар зорилт, Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 87-р тушаал “Эрсдэлийн удирдлагын стратеги” 2.1.3, 3.3, 5.2 дах заалт,				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Улирал</i>	<b>1-р улирал</b>	<b>2-р улирал</b>	<b>3-р улирал</b>	<b>4-р улирал</b>
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Батлагдсан төсвийн хүрээнд				
	<i>Суурь түвшин</i>	Шилэн хяналтын системд 2015 оноос одоог хүртэл нийт 126601 шалгуулагч этгээдийн 139468 объект бүртгэсэн байна. 2019 онд нийт 4561 шалгуулагч этгээдийн 6355 объектыг нэмж бүртгэсэн. Нийслэлийн хэмжээнд 2019 онд хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 44851 объектод ээлжит эрсдэлийн үнэлгээний санг бүрдүүлсэн.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	- Мэдээллийн санд бүртгэгдсэн 44851 объектод эрсдэлийн үнэлгээ хийсэн байх. - Шилэн хяналтын цахим системд эрсдэлийн ангилалд хамаарах объектын мэдээллийн сан үүсгэх - Эрсдэлийн үнэлгээний мэдээллийн санд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн төлөв байдлын талаар танилцуулга гаргах				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> Хяналт шалгалтын объектын 2019 оны эрсдэлийн үнэлгээний мэдээлэлд дүн шинжилгээ хийж, эрсдэлийн төлөв байдлын талаар танилцуулга гаргасан байна. <b>Жилийн эцэс:</b> Хяналт шалгалтын объектуудад эрсдэлийн үнэлгээ хийх ажлыг зохион байгуулж, “Шилэн хяналтын цахим систем”-д 2020 оны эрсдэлийн үнэлгээг бүртгэж, эрсдэлийн ангилалд хамаарах объектын жагсаалтаар нэгдсэн цахим санг бүрдүүлсэн байна. -Эрсдэлийн төлөв байдлын талаар байгууллагын вэб хуудсаар олон нийтэд мэдээлсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	1. НМХГ-аас 2020 онд 41299 объектод эрсдэлийн үнэлгээ хийлээ. Үүнээс их эрсдэлтэй 6658 (16.1%) , дунд эрсдэлтэй 28710 (69.5%), бага эрсдэлтэй 5931 (14.4%) үнэлэгдсэн. Энэ нь өмнөх оноос нийт эрсдэлийн үнэлгээ хийсэн объектын тоо 3552-оор буюу 7.9%-иар буурсан үзүүлэлттэй байна. Энэ нь хүнсний чанар, стандарт, эрүүл ахуй, халдвар хамгаалалын хяналтын чиглэлүүдийн шалгуур, үзүүлэлт нэгдсэн, мөн коронавирус халдвар гарсантай холбогдон олон аж ахуйн нэгж байгууллага үйл ажиллагаагаа зогсоосонтой холбоотой юм.  Их эрсдэлтэй объектын эзлэх хувь өмнөх оноос 3.5 пунктаар өссөн бол дунд эрсдэл 2.6 пунктаар, бага эрсдэл 0.9 пунктаар тус тус буурсан байна. 2. Хяналт шалгалтын 2015-2019 оны объектын эрсдэлийн үнэлгээний мэдээлэлд үндэслэн дүн шинжилгээ хийсэн.Дүн шинжилгээгээр нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй объектуудад хяналтын чиглэл бүрээр эрсдэлийн төлөв байдлыг сүүлийн 5 жилээр харьцуулан эмхэтгэл гаргасан. Ерөнхий үзүүлэлтийг авч үзвэл 2019 онд хяналтын 44851 объектод эрсдэлийн үнэлгээ хийж, 5658 (12.6%) их, 32344 (72.1%) дунд, 6849 (15.3%) бага эрсдэлтэй үнэлэгдсэн. Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектуудаас 2020 оны төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах объектуудыг сонгон төлөвлөлтийг хийж, хяналт шалгалтыг гүйцэтгэж, биелэлтийг хангуулж ажиллалаа. Өмнөх оноос эрсдэлийн үнэлгээ хийсэн объектын тоо747 буюу 1.7%-иар өссөн.Нийт объектод их эрсдэлтэй объектын эзлэх хувь өмнөх оноос 0.3 пунктаар, дунд эрсдэл 0.5 пунктаар тус тус буурсан бол бага эрсдэл 0.8 пунктаар өссөн байна. Мөн эрсдэлийн шалгуур үзүүлэлт бүрээр шаардлага хангаагүй асуумжаар дүн шинжилгээ хийж ажиллалаа. Дүн шинжилгээг эмхэтгэл болгон дотоод албан хэрэгцээнд ашиглахаар цахим болон цаасан хэлбэрээр удирдлагууд болон улсын /ахлах/ байцаагч нарт танилцуулж ажиллалаа.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-				
	<i>Хүрсэн түвшин</i>	-НМХГ-аас 2020 онд 41299 объектод эрсдэлийн үнэлгээ хийлээ. Үүнээс их эрсдэлтэй 6658 (16.1%) , дунд эрсдэлтэй 28710 (69.5%), бага эрсдэлтэй 5931				

	(14.4%) үнэлэгдсэн. -2019 оны объектын эрсдэлийн үнэлгээнд сүүлийн 5 жилийн байдлаар харьцуулсан дүн шинжилгээ хийж, эмхэтгэл гарган нийт удирдлагууд болон, улсын /ахлах/ байцаагч нарт цахим болон цаасан хэлбэрээр танилцуулж ажилласан.
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>	

<i>№1.1.1.2</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.2-р арга хэмжээ: <b>Хяналт шалгалтыг төлөвлөх ажлыг нэгдсэн бодлого, арга зүй, зохион байгуулалтаар хангаж, гүйцэтгэл үр дүнг тооцож ажиллах</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	ТХШТХ-ийн 5 <sup>1</sup> , Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 87-р тушаал “Эрсдэлийн удирдлагын стратеги” 2.1.3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	<i>Улирал</i>	<b>1-р улирал</b>	<b>2-р улирал</b>	<b>3-р улирал</b>	<b>4-р улирал</b>
	<i>Шаардагдах хөрөнөг</i>	Батлагдсан төсвийн хүрээнд				
	<i>Суурь түвшин</i>	2019 онд 3513 объектод 4940 шалгалт, 2299 объектод 2837 зөвлөн туслах үйлчилгээ, хяналтын бусад хэлбэрээр 145 асуудлыг хэрэгжүүлэн 98.7 %-ийн гүйцэтгэлтэй ажилласан. -МХЕГ-ын даргын 2019 оны А/159 дүгээр тушаалаар “Мэргэжлийн хяналтын байгууллагын 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөө”-г батлан, олон нийтэд зарласан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	- 4031 объектод 5371 шалгалт, 2207 объектод 2760 зөвлөн туслах үйлчилгээний гүйцэтгэл - Хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсан 136 ажлын гүйцэтгэл - Хяналт шалгалтын гүйцэтгэлд хийсэн дүн шинжилгээ - Холбогдох нэгж, байгууллагад мэдээллээр үйлчилж, дэмжлэг үзүүлсэн ажлын тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> Шилэн хяналтын цахим системд сар, улирал, хагас бүтэн жилээр хяналт шалгалтын гүйцэтгэлд хяналт тавьж, дүн шинжилгээ хийсэн байна. <b>Жилийн эцэст:</b> 2020 оны хяналтын шалгалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангуулж, 2021 оны хяналт шалгалтын төлөвлөгөөг батлуулж, олон нийтэд зарласан байна. 2020 оны жилийн эцсийн хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	-Жилийн эцсийн байдлаар /2020.12.07-ний өдөр/ шилэн хяналтын цахим системд төлөвлөгөөт шалгалт 5198 (95.3%), зөвлөн туслах үйлчилгээ 2719 (93.4%) объектод хяналт шалгалт хийгдсэн гүйцэтгэлтэй байна. Үүнээс үйл ажиллагаа зогссон төлөвтэй 650 шалгалт, 206 зөвлөн туслах үйлчилгээ байна. Урьдчилан сэргийлэх шалгалт 9068, хянан баталгаажуулах үйл ажиллагаа 681, тандалт судалгаа 755, хяналт шинжилгээ 684, салбарын сургалт 652 объектод хийгдсэн. Шилэн хяналтын цахим системд хяналт шалгалтын гүйцэтгэлд сар бүр хяналт тавьж, улсын /ахлах/ байцаагч бүрээр хяналт шалгалтын гүйцэтгэлийг тооцон, нийт 12 удаа мэдээ гарган ажиллалаа. Мөн төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээг шилэн хяналтын цахим системд хянаж, тухай бүр улсын /ахлах/ байцаагчдад мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, гарсан алдааг засуулж ажилласан. Мөн өмнөх оны хяналт шалгалтын гүйцэтгэл, осол, хордлогын мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцон, дүн шинжилгээг эмхэтгэл болон хэвлүүлж удирдлагуудад хүргүүлж, нийт улсын /ахлах/ байцаагч нарт цахимаар хүргүүлсэн. -2020 оны 06 дугаар сарын 19-ний өдөр Тамгын газраас цахимаар зохион байгуулсан “Улсын /ахлах/ байцаагч нарт зориулсан сургалт”-д шилэн хяналтын цахим системн тухай ерөхний ойлголт, хяналт шалгалтын мэдээлэл хэрхэн, яаж бүртгэх тухай сургалтыг 270 албан хаагчыг хамруулан хийсэн. -2020 оны 09 дүгээр сарын 07-ны өдрөөс 09 дүгээр сарын 15-ны өдрүүдэд НМХГ-ын даргын баталсан хөтөлбөрийн дагуу чиглэл болон дүүрэг дэх хэлтсүүдэд нийт 10 удаагийн сургалтаар 511 албан хаагчийг хамруулан, “Шилэн хяналтын цахим систем”-д хяналт шалгалтын мэдээлэл бүртгэхэд анхаарах асуудал сэдвээр сургалт зохион байгуулж ажилласан. -Удирдах ажилтан болон улсын /ахлах/ байцаагчдын ажлын гүйцэтгэлийн үзүүлэлтийг сар, улирал, хагас бүрэн жилээр буюу 9 удаа холбогдох хэлтсүүдээс авч нэгтгэн, удирдлагуудад танилцуулж ажилласан. - НМХГ-аас 2021 онд хийх хяналт шалгалтын төлөвлөлт хийх ажлыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажилласан. 2021 онд НМХГ-аас				

		4028 объектод хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 5533 шалгалт, 2584 объектод 3208 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	-2020 оны хяналт шалгалтын гүйцэтгэл: ШХЦС-д 2020.12.07-ны өдрийн байдлаар төлөвлөгөөт шалгалт 95.3%, зөвлөн туслах үйлчилгээ 93.4%-ийн гүйцэтгэлтэй байна. -НМХГ-аас 2021 онд 4028 объектод хяналтын чиглэлээр давхардсан тоогоор 5533 шалгалт, 2584 объектод 3208 зөвлөн туслах үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөсөн. -2 удаагийн дотоод сургалт зохион байгуулсан. -Өмнөх оны хяналт шалгалтын гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцон, эмхэтгэл болон албан хаагчдад танилцуулсан.
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>		

<i>№1.1.1.3</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.3-р арга хэмжээ: <b>Эрсдэлийн үнэлгээ болон хяналт шалгалтыг оновчтой, үр дүнтэй гүйцэтгэх баримт бичгүүдийг боловсронгуй болгох</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөөний 10 дугаар зорилт,				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Батлагдсан төсвийн хүрээнд				
	<i>Суурь түвшин</i>	2020 онд хяналт шалгалтад ашиглагдах хяналтын хуудсуудад нэмэлт өөрчлөлт оруулах, шинээр боловсруулахад НМХГ-аас 19 хяналтын хуудсанд нэмэлт өөрчлөлт оруулах 87, шинээр боловсруулах 10 саналыг нэгтгэн МХЕГ-ын ЭУСТГ-т хүргүүлсэн.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Шинээр болон шинэчлэн боловсруулсан хяналтын хуудас, эрсдэлийн шалгуур үзүүлэлтийн тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:-</b> <b>Жилийн эцэст:</b> Шинээр болон шинэчлэн боловсруулсан хяналтын хуудас, эрсдэлийн шалгуур үзүүлэлтүүдэд улсын /ахлах/ байцаагчдаас санал авч, саналыг нэгтгэн МХЕГ-т хүргүүлсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	НМХГ-аас 2020 онд ашиглах хяналтын хуудсуудад нэмэлт өөрчлөлт оруулах 87, шинээр боловсруулах 10 саналыг нэгтгэн цахимаар МХЕГ-ын ЭУСТГ-т хүргүүлсэн. МХЕГ-ын даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/32 дугаар “Хяналтын хуудас батлах тухай” тушаалаар шинээр 12, шинэчлэн 93 хяналтын хуудас батлагдан гарсан. Улсын /ахлах/ байцаагчид 2020 онд нийт 276 хяналт хуудсыг хяналт шалгалтандаа ашиглах юм. Тушаал болон 276 хяналтын хуудсуудыг НМХГ-ын цахим хуудас, ABLE программын Олон нийт цэсэнд байршуулсан.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-				
	<i>Хүрсэн түвшин</i>	2020 онд ашиглах хяналтын хуудсуудад нэмэлт өөрчлөлт оруулах 87, шинээр боловсруулах 10 саналыг хүргүүлж, МХЕГ-ын даргын тушаалаар 12 шинээр болон 93 шинэчлэн батлагдсан хяналтын хуудсуудыг тушаалын хамт улсын /ахлах/ байцаагчдад хүргүүлж, олон нийтэд нээлттэйгээр байгууллагын вэб сайтад байршуулсан.				
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>						

<i>№1.1.1.4</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.1.4-р арга хэмжээ: <b>Хяналт шалгалтын үр дүн, эдийн засгийн хэмнэлт, үр ашгийн тооцох аргачлал боловсруулах судалгаа</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөөний 10 дугаар зорилт, Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 87-р тушаал “Эрсдэлийн удирдлагын стратеги” 3.3 дах заалт				
Гүйцэтгэлийн	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал

шалгуур үзүүлэлт	Шаардагдах хөрөнгө	Батлагдсан төсвийн хүрээнд
	Суурь түвшин	“Хяналт шалгалтын үр дүн, эдийн засгийн хэмнэлт, үр ашгийг тооцох аргачлал боловсруулах судалгаа”-г бизнес эрхлэгчид болон улсын /ахлах/ байцаагчдаасавсан.
	Шалгуур үзүүлэлт	SPSS программд өгөгдөлийг оруулсан байна.
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> Хяналт шалгалтын үр дүн, эдийн засгийн хэмнэлт, үр ашгийн тооцох аргачлал боловсруулах судалгааг SPSS программд оруулан, дүн шинжилгээ анализ хийж МХЕГ-т хүргүүлнэ. <b>Жилийн эцэст:</b> -
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	“Хяналт шалгалтын үр дүн, эдийн засгийн хэмнэлт, үр ашгийг тооцох аргачлал боловсруулах судалгаа”-г 184 бизнес эрхлэгчид болон 92 улсын /ахлах/ байцаагчид, төрийн байгууллагын төлөөллөөс 8, нийт 284 судалгааг авсан. Эдгээр 284 судалгааг SPSS программд оруулан, нээлттэй асуултуудыг нэгтгэн МХЕГ-ын ЭУСТГ-т 2020 оны 08 дугаар сарын 24-ны өдөр цахимаар /файлаар/ хүргүүлсэн.
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	284 судалгааг SPSS программд шивж оруулсан.
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ		

**Гүйцэтгэлийн зорилт №1.1.2. Аж ахуйн нэгж, байгууллагын дотоод хяналтыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.**

№1.1.2.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.2.1-р арга хэмжээ: <b>Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулахад дэмжлэг үзүүлнэ.</b>					
	Төлөвлөлтийн уялдаа:	Засгийн газрын 2011 оны 311-р тогтоол, “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”, Авилгатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 4.1.2.4.2 дах заалт				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	<b>3-р улирал</b>	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Батлагдсан төсвийн хүрээнд				
	Суурь түвшин	МУЗГ-ын 2011 оны 311-р тогтоолоор “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам” батлагдсан.				
	Шалгуур үзүүлэлт	Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартын төсөлд оруулсан саналын тоо				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> <b>Жилийн эцэст:</b> - Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын стандартыг шинээр боловсруулахад санал авч, МХЕГ -т хүргүүлсэн байх.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг шинэчлэн боловсруулахад чиглэл болон дүүрэг дэх МХХ-ээс санал авч нэгтгэн 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 02-04/4815 тоот албан бичгээр МХЕГ-т хүргүүлсэн.				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хүрсэн түвшин	Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 311 тогтоолоор баталсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ыг шинэчлэн боловсруулахад тусгах 14 саналыг МХЕГ-т хүргүүлсэн.				
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ						

№1.1.2.2	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.2.2-р арга хэмжээ: <b>Дотоод хяналтын соёл нэвтрүүлсэн байгууллагыг бэлтгэх</b>				
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 87-р тушаал Эрсдэлийн удирдлагын стратегийн 4 дэх хэсэг, “Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны дунд хугацааны төлөвлөгөө”-ний 10 дугаар зорилт			

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
		<i>Шаардагдах хөрөнгө</i>	Батлагдсан төсвийн хүрээнд			
	<i>Суурь түвшин</i>	Дотоод хяналтын соёлыг нэвтрүүлэх чиглэлээр хамтран ажиллах 4 байгууллагыг сонгосон.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Түшиц 4 байгууллагатай хамтран ажиллан, бусад бизнесийн байгууллагад туршлага хуваалцах арга хэмжээг зохион байгуулсан байх				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b>                      -Дотоод хяналтын соёл нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагуудыг бэлтгэж, бусад 100бизнесийн байгууллагад туршлага хуваалцах арга хэмжээг хамтран зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах арга зүйгээр хангасан байна.  <b>Жилийн эцэст:-</b></p>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>“Эрсдэлийн төлөв байдалд хийсэн дүн шинжилгээг олон нийтэд танилцуулах арга хэмжээ”-г 2020 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр Кемпински зочид буудлын хурлын танхимд МХЕГ-тай хамтран зохион байгуулсан. Арга хэмжээнд нийт 134 бизнес эрхлэгчийн төлөөлөл оролцсон. МХЕГ-ын ЭУСТГ-аас танигдах илтгэлийг хамтран бэлтгэсэн.</p> <p>НМХГ-тай Монфа эмийн сан, Удвал дент шүдний эмнэлэг, Жунсон констракшн, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв зэрэг 4 байгууллага хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурсан.</p> <p>- Түшиц 4 байгууллагыг МХЕГ-ын дотоод хяналтын түшиц байгууллагууд чат группт бүртгэн, цахим сургалтын мэдээллийг хүргэж, хамтран ажилласан.</p> <p>- 2019 оны хяналтын хуудсаар хяналт шалгалтад хамрагдсан ААНБ-уудын мэдээлэлд үндэслэн дотоод хяналтын асуумжаар 17 хяналтын чиглэлийн 30 хяналтын хуудсанд дүн шинжилгээ хийсэн.</p>				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-				
	<i>Хүрсэн түвшин</i>	4 байгууллагатай хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурж, бизнес эрхлэгч 134 төлөөлөгч сургалтаар туршлага хуваалцах арга хэмжээг зохион байгуулж, эрсдэлээс урьдчилан сэргийлж ажиллах арга зүйгээр хангасан.				
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>						

№1.1.2.3	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.2.3-р арга хэмжээ: <b>Аж ахуйн нэгж байгууллагын порталыг хөгжүүлж, ашиглалтыг нэмэгдүүлэх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 87-р тушаал Эрсдэлийн удирдлагын стратегийн 4 дэх хэсэг, “Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны Дунд хугацааны төлөвлөгөө”-ний 10.2 дах заалт				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Батлагдсан төсвийн хүрээнд				
	<i>Суурь түвшин</i>	khyanal.gov.mn олон нийтийн порталаар дамжуулан Мэргэжлийн хяналтын байгууллага эрсдэл өндөртэй үнэлэгдсэн аль байгууллагад, хэзээ, ямар хяналтын чиглэлээр төлөвлөгөөт хяналт шалгалт хэрэгжүүлэхийг ил тод байршуулж хэвшсэн.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	- Аж ахуйн нэгж, байгууллагын порталыг хөгжүүлэх -Аж ахуйн нэгж, байгууллагын порталашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээний тоо -Аж ахуйн нэгж, байгууллагын портал ашиглагч хэрэглэгчийн тоо				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b>Аж ахуйн нэгж, байгууллагын портал ашиглалтыг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт сурталчилгааны ажил зохион байгуулсан байна.</p> <p>-Аж ахуйн нэгж байгууллагуудад шилэн хяналтын цахим системийг ашиглах тухай сургалтыг хэлтсүүдтэй хамтран зохион байгуулсан байна.  <b>Жилийн эцэс:</b>2020 оны хяналт шалгалтанд хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагуудад порталыг сурталчилж, ашиглаж хэвшүүлсэн байна.</p>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	НМХГ-аас 2020 онд төлөвлөгөөт шалгалт, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн нийт 5417 объектод шилэн хяналтын цахим системийн аж ахуйн нэгжийн порталыг сурталчилж, ажилласан. Мөн порталыг ашиглах тухай гарын авлагыг МХЕГ-ын ЭУСТГ-тай хамтран шинэчлэн боловсруулж, нийт 420				



		ширхэгийг хэвлэж бэлтгэсэн. Үүнд: хэлтсүүдэд 290 ширхэгийг хүргүүлж, зөвлөгөө мэдээллийн төв (бичиг хэрэг)-д иргэдэд танилцуулах зорилгоор 130 ширхэг байршуулсан. Чиглэл болон дүүрэг дэх хэлтсүүд хяналт шалгалтын үеэрээ порталын сурталчилж ажилласан.
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	5417 объектод шилэн хяналтын цахим системийн аж ахуйн нэгжийн порталыг сурталчилж, 420 ширхэг брошур гарын авлагыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад тараасан.
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ		

**Гүйцэтгэлийн зорилт №1.1.3.Лабораторийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан зарчмыг нэвтрүүлэх**

№1.1.3.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин					
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.3.1-р арга хэмжээ: <b>Лабораторийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийх</b>					
	Төлөвлөлтийн уялдаа:	Монгол Улсын Шадар сайдын 2014 оны 87 дугаар тушаал, Эрсдэлийн удирдлагын стратегийн 3.3 дах хэсэг, “Мэргэжлийн хяналтын байгууллагын 2018-2020 оны Дунд хугацааны төлөвлөгөөний10 дугаар зорилт				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Батлагдсан төсвийн хүрээнд				
	Суурь түвшин	-“Бизнес эрхлэгчдэд лабораторийн шинжилгээтэй холбоотой тулгамдсан асуудлыг тодорхойлох” тандалт судалгааг лабораторийн ажилтнууд, 10 бизнес эрхлэгчдийг хамруулан хэрэгжүүлж, мэдээллийг боловсруулсан.				
	Шалгуур үзүүлэлт	Эрсдэлийн шалгуур боловсруулах, санал өгөх				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жил:</b> Лабораторийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийсэн байна. <b>Жилийн эцэс:</b> Лабораторийн үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	2020 оны 05 дугаар сарын 18-ны өдөр НМХГ-ын Төв лабораторид, 05 дугаар сарын 15-ны өдөр Налайх, Багануур дүүрэг дэх салбар лабораториудад учирч болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, аюулыг арилгах зорилгоор эрсдэлийн үнэлгээг 6 чиглэлээр 40 асуулттай асуумжаар хийхэд өдөр тутмын шинжилгээнд шаардлагатай багаж, тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, тэжээлт орчин, эм урвалжийн хүрэлцээ муу хангалттай биш, шинжээч нарыг мэргэжлийн байгууллагуудаас зохион байгуулж буй сертификаттай сургалтанд хамруулах шаардлага тулгамдаад байгаа зэрэг нь үнэлгээгээр их эрсдэлтэйд тооцогдож байна. Иймд дээрх шаардлагатай хөрөнгө зардлыг төсөвт суулгаж, яаралтай шийдвэрлүүлэх шаардлагатай байгааг холбогдох дээд байгууллагуудад санал хүргүүлсэн.				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хүрсэн түвшин	Төв лаборатори, БГД, НД дэх МХХ-ийн лабораториудын үйл ажиллагаанаас үүсч болзошгүй эрсдэлийн үнэлгээ хийж, шаардлагатай хөрөнгө зардлыг төсөвт суулгаж, яаралтай шийдвэрлүүлэх шаардлагатай байгааг асуудлуудыг холбогдох газарт хүргүүлсэн.				
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ						

**Гүйцэтгэлийн зорилт №1.1.4. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдээс мэргэжлийн хяналтын байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах**

№1.1.4.1	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин	
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.1-р арга хэмжээ: <b>Хүнсний боловсруулах үйлдвэрт эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэвшүүлэх зааврыг батлах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах</b>	
	Төлөвлөлтийн уялдаа:	МУЗГҮАМХ-ийн 2.23.2

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Батлагдсан төсвийн хүрээнд				
	<i>Суурь түвшин</i>	2019 онд 159 үйлдвэрт шалгалт хийснээс зохистой дадал нэвтрүүлж, баталгаажуулсан хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо 20 болж 10% -иар нэмэгдэж хүрэх түвшингийн үзүүлэлтийг хангасан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Зохистой дадлыг хэвшүүлэх чиглэлээр хийсэн ажлын хэрэгжилтийн хувь				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> Зохистой дадал нэвтрүүлж, баталгаажуулсан хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн тоог 12,5% -аар нэмэгдэх <b>Жилийн эцэст:</b> Зохистой дадал нэвтрүүлж, баталгаажуулсан хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо 15% -аар нэмэгдсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад хамрагдсан 99 хүнсний үйлдвэр цехээс ГБТ трейдинг ХХК, Хүнс комплекс ХХК-иуд /GMP, GHP/ үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадал, чанарын удирдлагын тогтолцооны стандарт ISO9001-г нэвтрүүлэн ажиллаж байсан бол жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан үйлдвэрүүдээс Макс хүнс ХХК, Отгон саран ХХК, Русские колбасы ХХК-иуд үйл ажиллагаандаа үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн/GMP, GHP/ зохистой дадлыг нэвтрүүлсэн ажиллаж байна.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	- Батлагдсан төсвийн хүрээнд				
	<i>Хүрсэн түвшин</i>	Зохистой дадал нэвтрүүлж, баталгаажуулсан хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийн тоо 2-оор нэмэгдсэн.				
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>						

№1.1.4.2		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.2-р арга хэмжээ: Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ, аудитад дүн шинжилгээ хийж, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУЗГҮАМХ-ийн 4.1.3.1				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	Батлагдсан төсвийн хүрээнд				
	<i>Суурь түвшин</i>	Нийслэлийн нутаг дэвсгэрт нийт 2247.42 га талбай эвдрэлд орсноос 110.8 га-д техникийн нөхөн сэргээлт, 25.8 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулах ажлын хэрэгжилтийн хувь				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулсан байна. <b>Жилийн эцэст:</b> Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хянан баталж, хэрэгжилтийг хангуулсан байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Шалгалтад 27 тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгж хамрагдаж, түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт заасан байгаль орчныг хамгаалах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үүргээ биелүүлээгүй байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөг батлуулаагүй 3 ААН-д Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу зөрчлийн хэрэг нээн шалгаж, илэрсэн зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 7.12 дугаар зүйлийн 2 дах хэсэгт зааснаар 1500.0 мян.төг-ийн торгуулийн арга хэмжээ, зөрчлийн үр дагавар арилгах даалгавар хүргүүлээ. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх ажлын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтран баталсан “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн биелэлтийг МХЕГ-т хүргүүлсэн. Хяналт шалгалтаар нийслэлийн нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч 114 ААН-д 02-02/3347 тоот албан мэдэгдлийг хүргүүлж, нөхөн сэргээсэн талбайн хэмжээг гаргасан. Мөн арга хэмжээний хүрээнд Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан, Хан-Уул, Налайх, Багануур, Багахангай дүүргүүдэд түгээмэл тархацтай				

		<p>ашигт малтмлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй, тусгай зөвшөөрөл нь цуцлагдсан нийт 267 аж ахуй нэгжийн талбайгаас эвдэгдсэн газрын хэмжээг 2412.07 га гэж тогтоосон ба үүнээс 38.48 га талбай буюу 1,5 хувь нь эзэнгүй орхигдсон, 2373.44 га талбай буюу 98,5 хувь нь хариуцах эзэнтэй байна.</p> <p>Нийт эвдэгдсэн газраас Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх дүүргүүдэд энэ оны 10 дугаар сарын байдлаар 231,59 га талбайд буюу 9.3 хувьд нь нөхөн сэргээлт хийлгүүлэн ажилласан бөгөөд үүнээс биологийн нөхөн сэргээлт 72.28 га талбайд буюу 30 хувьд, техникийн нөхөн сэргээлт 162.39 га талбайд буюу 70 хувьд хийсэн талаар тайлан ирүүлсэн байна.</p>
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан.
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ		

№1.1.4.3		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.3-р арга хэмжээ: <b>Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын хүрээнд бүх шатны Засаг дарга нарын Ойн түймрээс урьдчилан сэргийлж, хамгаалах талаар "Ойн тухай" хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг шалгаж хэрэгжилтийг хангуулж ажиллах</b>					
	Төлөвлөлтийн уялдаа:	МУЗГҮАМХ-ийн 4.2.7.3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	Батлагдсан төсвийн хүрээнд				
	Суурь түвшин	Ойн түймэрт өртөх талбайн хэмжээг 20 хүртэл хувиар бууруулсан.				
	Шалгуур үзүүлэлт	Ойн түймрээс урьдчилан сэргийлж, хамгаалах талаар хүлээсэн үүргийн биелэлтийн хувиар				
	Хүрэх түвшин	<p><b>Эхний хагас жилд:</b> Ойн түймэрт өртөх талбайн хэмжээг 25 хүртэл хувиар бууруулсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Ойн түймэрт өртөх талбайн хэмжээг 30 хүртэл хувиар бууруулсан байна.</p>				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Нийслэлийн Засаг даргын 2020 оны А/376 дугаар захирамжийг үндэслэн Ой, хээрийн түймэр, хууль бусаар байгалийн нөөц баялаг ашиглахаас хамгаалах, урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх НМХГ-ын даргын 2020 оны А/37 тоот тушаал гаргуулан Нийслэлийн ногоон бүс, нутаг дэвсгэрт хавар намрын хуурайшилтын үед ой, хээрийн түймрээс хамгаалах, хууль бусаар мод, байгалийн дагалт баялаг бэлтгэлд, ан агнуур тэдгээрийн тээвэрлэлтийн байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах хуваарь, шатахууны зардлын гаргаж эргүүл шалгалтыг нийт байгаль орчны хяналтын 38 улсын /ахлах/ байцаагч нар нийслэлийн нутаг дэвсгэрт хийлээ.</p> <p>Ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, хууль бус мод бэлтгэлт, ан агнууртай тэмцэх хяналт шалгалтыг ногоон бүс бүхий Сонгинохайрхан, Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх, Хан-Уул, Налайх, Багахангай, Багануур дүүргүүдийн нутаг дэвсгэр болох Жаргалант, Цагаан чулуут, Бороож, Ар Тарвагатай, Хөндлөнгийн ам, Шар хадны ам, Ар Гүнт, Өвөр Гүнт, Баянголын ам, Тахилт, Баруунтуруун, Толгойтын баруун салаа, зүүн салаа, Салхит, Хар шороотын ам, Шижирийн даваа, Найрамдал зуслан, Жигжид, Билгүүний ар, Яргайт, Яргайтын богино, Шадивлин, Шарга морьт, Гоодой, Санзай, Майхан толгой, Их баян, Бага баян, Хандгайт, Хуурай мухар, Баянбулаг, Бэлх, Сэлх, Чингэлтэй уул, Зүрх уул, Гачуурт, Шар хоолойн ам, Их, Бага Дээндий, Баянзүрх уул, Баяндөхөм, Гүнжийн хоолой, Улиастай эх, Хадатын ам, Улайстайн баруун, Зүүн салаа, Баянголын ам, Шарын ам, Шургуутын даваа, Хонхор, Хүрэл тогоотын ам, Залаат, Нүхт, Жаргалантын ам, Өлзийт, Куветын ам, Шувуун фабрик, Бугын сангийн аж ахуй, Хэрлэнгийн гүүр зэрэг газруудаар батлагдсан хуваарийн дагуу давхардсан тоогоор 50 удаагийн хөдөлгөөнт эргүүл, хяналт шалгалтыг зохион байгуулж, нийт 5000 км орчим зам туулан, 1200000 /нэг сая хоёр зуун мянган/ төгрөгийн шатахуун зарцуулж, хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн, тухайн нутаг дэвсгэрт үүрэг гүйцэтгэж буй байгаль хамгаалагчдын ажлыг шалган заавар, зааварчилгаа, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, түймрийн үед хэрэглэгдэх багаж</p>				

		хэрэгслийг шалгаж, ногоон бүсийн нутаг дэвсгэрт оршин суудаг, үйлчилгээ, үйл ажиллагаа эрхэлдэг, авто тээвэр шалган бүртгэх товчоодоор нэвтэрч буй зэрэг нийт 125 аж ахуйн нэгж, байгууллага, 630 иргэний үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, холбогдох хууль тогтоомжийг сурталчилан таниулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллалаа. Ногоон бүсэд оршин суудаг айл өрхүүд өөрийн эзэмшлийн талбайн хуучин шар өвсийг шатааж байгаад ойр орчимдоо гал алдах зэрэг хариуцлагагүй үйлдлээс болж ахуйн түймэр гарах, цаашлаад ой, хээрийн түймэр тавих эрсдэл дагуулж байдаг тул энэ асуудал дээр иргэдэд сэрэмжлүүлэг, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, урьдчилан сэргийлж ажиллалаа.
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	2020 онд нийслэлийн ногоон бүсэд түймэр гараагүй, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдаж ажилласан.
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ		

<b>№1.1.4.4</b>		<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>				
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.4 арга хэмжээ:Тусгай зөвшөөрөлтэй эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд тавих хяналтын нэгдмэл байдлыг хангах</b>					
	Төлөвлөлтийн уялдаа:	МУЗГҮАМХ-ийн 1.19.4				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Суурь түвшин	Хяналтын давхардлын тоо 70 хүртэл хувиар буурсан байна.				
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:80%</b> <b>Жилийн эцэст: 90%</b>				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс гаргасан чиглэлийн хүрээнд Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын хамтарсан “Эрүүл мэндийн даатгалын сан болон сангаас санхүүжиж буй эрүүл мэндийн байгууллагуудад” урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд эрүүл мэндийн даатгалын газартай хамтран эмчилгээний чанарын хяналт, нийгмийн хамгаалал, цөм болон цацрагийн хяналтын чиглэлээр шалгалтыг хийж гүйцэтгэлээ Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад удирдамжид зааснаар нийслэлд нийт 68 эмнэлэг харагдахаас 61 эмнэлэг буюу 89.7% нь хамрагдсан байна. Шалгалтад хамрагдсан эмнэлгүүдийг төрлөөр нь авч үзвэл: төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг 4, дүүргийн эрүүл мэндийн төв 6, нэгдсэн эмнэлэг 1, өрхийн эрүүл мэндийн төв 28, хувийн хэвшлийн ортой эмнэлэг 22 нийт 61 эмнэлэг хамрагдсан.Удирдамжийн хүрээнд баримт бичиг хянах, тайлбар, тодорхойлолт, мэдээлэл судалгаа, баримт авах эргэмж судалгааныаргуудаартусламж үйлчилгээ үзүүлсэн эмнэлгүүдийн 1978 баримт, бүртгэлд эргэмж судалгааны аргаар хяналт хийлээ.</p> <p>1. Тусламж үйлчилгээ үзүүлсэн төрөлжсөн мэргэжлийн эмнэлгүүдийн 4 эмнэлгийн 152 эмнэлгийн баримтыг шалгахад амбулаторийн тусламж үйлчилгээ, үзлэг оншилгоо, шинжилгээг стандарт, эмнэлзүйн удирдамж, зааврын дагуу үзүүлсэн байдал 84,7%хэрэгжилттэй.</p> <p>2. Өдрийн болон хэвтүүлэн эмчлэх тусламж үйлчилгээ үзүүлсэн 7 эрүүл мэндийн төв эмнэлгийн 468 баримт, хувийн хэвшлийн ор бүхий эмнэлгүүдийн 410 өвчний түүх, өрхийн эрүүл мэндийн 948 өвчний түүх, бүртгэлд эргэмж судалгааны аргаар өдрийн эмчилгээ хийгдсэн байдлыг авч звэл: Оношилгоо, оношийн үндэслэл 86.5%, эмчилгээ, сувилгааны заалт 87.6%, стандарт, эмнэлзүйн зааврын мөрдөлт 82 %, өдрийн болон хэвтэн эмчлэх эмчилгээний үр дүнг тооцсон байдал 78.3 %-ийн биелэлтэй байна.</p> <p>3. Өрхийн эрүүл мэндийн төвүүдэд өвчний түүхийн бичилт, стандарт удирдамжийн мөрдөлтийн шалгуур үзүүлэлт оношилгоо, оношийн үндэслэл 79.7%, эмчилгээ, сувилгааны заалт 63%, стандарт, эмнэлзүйн зааврын мөрдөлт 70.1%, Гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлэх болгонд “Гэрээр сувилахуйн тусламж үзүүлэх захиалгын хуудас”-нд урьдчилантэмдэглэсэн, эмчийн заалтын дагуу шаардлагатай гэж түүвэрлэн авсан үйлчлүүлэгчид “Гэрээр үзүүлсэн сувилхуйн тусламжийн хуудас”-ыг нэг бүрчлэн хөтлөж хэвшсэн, харин сэргээн засах чиглэлээр</p>				

		мэргэшсэн их эмч, сувилагч 8%, Анан, Тэгш-Өлзий өрхийн эрүүл мэндийн төвүүд нь өдрийн эмчилгээ хийх өрөө тасалгаа дутагдалтай нь байгаа нь Өрхийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагаа MNS5292:2017 стандартыг хангахгүй байна.
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Хяналт шалгалтын давхардал буурсан. Урьдчилан сэргийлэх хяналт шалгалтад нийслэлд нийт 68 эмнэлэг харагдахаас 61 эмнэлэг буюу 89.7% нь хамрагдсан. -Мэдээлэлийн сантай болсон. -Шинээр гарсан хууль тогтоомж, тушаал шийдвэрийн хэрэгжилт хангагдаж хяналт шалгалтын давхардал буурсан.
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>		

<b>№1.1.4.5</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.5 арга хэмжээ: Нийтийн зориулалттай орон сууцны барилгын ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчлэх ажилд хяналт тавина.</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУЗГҮАМХ-ийн 2.85.5				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-				
	<i>Суурь түвшин</i>	Шинээр сольсон нийт 23 лифтийг хяналт шалгалтанд хамруулсан. 120 лифтийг улсын бүртгэлд бүртгэж ашиглах зөвшөөрөл олгосон байна.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> Ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчилсэн байна. <b>Жилийн эцэст:</b> Ашиглалтын шаардлага хангахгүй лифтийг шинэчилсэн байна.				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Нийтийн орон сууцанд шинээр сольсон 4 лифтийн угсралт, техникийн байдалд хяналт шалгалтыг хийж ашиглалтанд оруулав.				
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-				
	<i>Хүрсэн түвшин</i>	Нийтийн орон сууцны 4 лифтийг 100% ашиглалтад оруулсан.				
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>						

<b>№1.1.4.6</b>	<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>					
Арга хэмжээний нэр, дугаар	<b>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.6 арга хэмжээ: Мод, модон материалын эрэлт нийлүүлэлтийн оновчтой арга хэмжээ авах, хуулийн хариуцлагыг чангатгах, иргэдийн оролцоог урамшуулах замаар хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох</b>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУЗГҮАМХ-ийн 4.1.3.2				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-				
	<i>Суурь түвшин</i>	Хууль бус мод бэлтгэлийг 2018 оны түвшнээс 50 хувиар бууруулсан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Хууль бус мод бэлтгэлийг таслан зогсоох				
	<i>Хүрэх түвшин</i>	<b>Эхний хагас жилд:</b> 50 <b>Жилийн эцэст:</b> 100				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	Нийслэлд мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулдаг 9 ойн мэргэжлийн байгууллагад төлөвлөгөөт шалгалт хийж зөрчилтэй 8 аж ахуйн нэгжид 8.000.000 /найман сая/ төгрөгийн торгууль, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулж, 72 куб.метр модыг гарал үүслийн гэрчилгээгүйгээр тээвэрлэж байсныг Экологийн цагдаагийн албанд шалгуулахаар шилжүүллээ. Нийт 15850000/ 15 сая 850 мянган/ төгрөгийн торгууль ногдуулан барагдуулж, 22.982.000 /22 сая 982 мянган/ нөхөн төлбөр оногдуулсан.				

		<p>Мөн хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, ойн ашиглалтад тавих хяналтыг эрчимжүүлэх чиглэлээр Хөвсгөлаймгийн Хөвсгөл аймгийн Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Түнэл, Рашаант, Төмөрбулаг, Мөрөн, Шинэ-Идэр, Галт, Жаргалант, Төв аймгийн Мөнгөнморьт сумдууд нийслэлийн ногоон бүсэд ойд үйлдвэрлэлийн ашиглалт, арчилгаа, цэвэрлэгээ, ойн аж ахуйн арга хэмжээний үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн Байгаль орчны чиглэлийн хууль тогтоомжийн мэдлэгийг дээшлүүлэх, урьдчилан сэргийлэх, зорилгоорхяналт шалгалт хийж гүйцэтгэлээ.</p> <p>Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дох заалтын хэрэгжилт Тариалан, Их-Уул, Тосонцэнгэл, Түнэл, Төмөрбулаг, Шинэ-Идэр, Галт, Жаргалант Төв аймгийн Мөнгөнморьт сумдад хангалтгүй тухайн жилд ойгоос бэлтгэх модны дээд хэмжээний төлөвлөгдсөн хэмжээнээс хэтрүүлэн мод бэлтгэх хуваарийн захиалга өгч батлуулсан байна.</p> <p>Галт, Жаргалант сумдад мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулдаг 9 ойн мэргэжлийн байгууллага шалгалтад хамрагдсанаас хөдөлмөрийн хяналтын чиглэлээр 7 аж ахуйн нэгж, байгаль орчны хяналтын чиглэлээр 3 аж ахуйн /"Түмний Хүрд" ХХК, "Жоншт Оргил хайрхан" ХХК, "Улаан гозгор" ХХК, "Гурван Цалуу" ХХК, "Их харгана ундраа" ХХК, "Галт Хүрэмт" ХХК, "Идэр зориг" ХХК, "Галт Овоот" ХХК, Хөх дөрвөлжин ХХК, Сайхан санаа ХХК/ нэгжид хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж 14.000.000 /найман сая/ төгрөгийн торгуулийн арга хэмжээ авахуулах тухай эрх бүхий албан тушаалтны даалгавар өгч, 3 аж ахуйн нэгжид 9 заалт бүхий улсын байцаагчийн албан шаардлага өгч, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч ажиллалаа.</p> <p>Түнэл сумын 2 дугаар багийн нутаг дэвсгэрт энэ оны 02 дугаар сарын 21-ний өдөр 20-32 ХӨА, 67-82ХӨВ улсын дугаартай зил 131 маркийн тээврийн хэрэгслээр 72 куб.метр модыг гарал үүслийн гэрчилгээгүйгээр тээвэрлэж явсныг шалгахад И.Улаанхүү, М.Баасансүрэн нар хууль бусаар мод бэлтгэсэн болохыг тогтоон материалыг Экологийн цагдаагийн албанд шалгуулахаар шилжүүлэн өгсөн.</p>
	<i>Зарцуулсан хөрөнгө</i>	-
	<i>Хүрсэн түвшин</i>	Хууль бус мод бэлтгэлийн тоо өмнөх жилүүдээс 50 хувиар буурсан байна.
<i>Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ</i>		

<i>№1.1.4.7</i>	<i>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</i>					
Арга хэмжээний нэр, дугаар	<i>Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.7 арга хэмжээ: Ус хангамжийн эх үүсвэрт эрүүл ахуйн бүс тогтоож, дэглэмийг мөрдүүлэх</i>					
	<i>Төлөвлөлтийн уялдаа:</i>	МУЗГУАМХ-ийн 4.2.5.6				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	<i>Хэрэгжих хугацаа</i>	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	<i>Шаардагдах хөрөнгө</i>	-				
	<i>Суурь түвшин</i>	Ундны усны эх үүсвэрийн хамгаалалт сайжирч, баталгаат байдал хангагдсан.				
	<i>Шалгуур үзүүлэлт</i>	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь				
	<i>Хүрэх түвшин</i>	<p><b>Эхний хагас жилд:</b> Ундны усны эх үүсвэрийн хамгаалалт сайжирч, баталгаат байдал хангагдсан байна.</p> <p><b>Жилийн эцэст:</b> Ундны усны эх үүсвэрийн хамгаалалт сайжирч, баталгаат байдал хангагдсан байна.</p>				
Арга хэмжээний хэрэгжилт	<i>Хэрэгжилт</i>	<p>МХЕГ-ын даргын баталсан 2020.11.13-ны өдрийн 01/247 дугаартай "Ундны ус хангамж, бохир ус, цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх" удирдамжийн хүрээнд Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн 7 эх үүсвэрийн насас станц болон УСУГ-ын 280 ус түгээх байр, иргэний 1 гүний худаг, бие даасан эх үүсвэртэй хотхоны 11 гүний худаг нийт 299 объектоос 466 усны дээж авч НМХГ-ын Төв лаб, ХАБҮЛЛ-д хими, нян судлалын үзүүлэлтээр шинжлүүлсэн.</p> <p>- Улаанбаатар хотын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрүүд дээр үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. 7 эх үүсвэрийн насос станц дээр хяналт хийх явцад усны дээжинд үлдэгдэл хлор тодорхойлоход 0.14-0.4 мг/л агууламжтай байв.</p> <p>- Хан-Уул дүүргийн 11 дүгээр хороо Астра вилла, Женерал таун хотхоны гүний худгийн усанд нянгийн бохирдол илэрсэн тул гүний худаг, ус нөөцлөх</p>				

		савыг угааж, халдваргүйжүүлэх ажил хийгдэж, түүний дараа авсан усны дээжийн хариу хүлээгдэж байна.
	Зарцуулсан хөрөнгө	-
	Хүрсэн түвшин	Ундны усны эх үүсвэрт эрүүл ахуйн хамгаалалтын дэглэм хангагдаж, усны чанар аюулгүй байдал стандартын шаардлагад нийцсэн.
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ		

№1.1.4.8		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.8 арга хэмжээ: <b>Аж ахуйн нэгж, мэргэжлийн байгууллагын үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх, чадавхыг бэхжүүлэх замаар нөхөн сэргээлтийн ажлын чанар үр дүнг дээшлүүлэх, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх</b>					
	Төлөвлөлтийн уялдаа:	МУЗГҮАМХ-ийн 4.2.6.3				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Суурь түвшин	2019 онд хийгдсэн тандан судалгаагаанаас үзэхэд Нийслэлийн нутаг дэвсгэрт нийт 2247.42 га талбай эвдрэлд орсны 110.8 га-д техникийн нөхөн сэргээлт, 25.8 га-д биологийн нөхөн сэргээлт хийсэн байна.				
	Шалгуур үзүүлэлт	Үйл ажиллагааны хэрэгжилт хувь				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд: 50</b> <b>Жилийн эцэст: 100</b>				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	<p>Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Цагдаагийн ерөнхий газрын даргын хамтран баталсан “Нөхөн сэргээлт-2020” ерөнхий арга хэмжээ зохион байгуулах төлөвлөгөөний дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэн биелэлтийг МХЕГ-т хүргүүлсэн. Хяналт шалгалтаар нийслэлийн нутаг дэвсгэр дэх ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзшигч 114 ААН-д 02-02/3347 тоот албан мэдэгдлийг хүргүүлж, нөхөн сэргээсэн талбайн хэмжээг гаргасан.</p> <p>Мөн арга хэмжээний хүрээнд 267 аж ахуй нэгжийн талбайгаас эвдэгдсэн газрын хэмжээг 2412.07 га гэж тогтоосон ба үүнээс 38.48 га талбай буюу 1,5 хувь нь эзэнгүй орхигдсон, 2373.44 га талбай буюу 98,5 хувь нь хариуцах эзэнтэй байна.</p> <p>Нийт эвдэгдсэн газраас Хан-Уул, Баянзүрх, Сонгинохайрхан, Налайх дүүргүүдэд энэ оны 10 дугаар сарын байдлаар 231,59 га талбайд буюу 9.3 хувьд нь нөхөн сэргээлт хийлгүүлэн ажилласан бөгөөд үүнээс биологийн нөхөн сэргээлт 72.28 га талбайд буюу 30 хувьд, техникийн нөхөн сэргээлт 162.39 га талбайд буюу 70 хувьд хийсэн талаар тайлан ирүүлсэн байна.</p>				
	Зарцуулсан хөрөнгө	Батлагдсан төсвийн хүрээнд				
	Хүрсэн түвшин	Нийт эвдэгдсэн 2247.42 га талбайгаас Багануур, Налайхын уурхайн эвдэгдсэн, эзэнгүй орхигдсон 1884.7 га талбайг хасч нийслэл дэх эвдэгдсэн талбайн хэмжээ 362.72 га-аас биологийн нөхөн сэргээлт 72.28 га талбайд буюу 30 хувь техникийн нөхөн сэргээлт 162.39 га /нийт 234.67 га/ талбайд хийгдсэн байна. Хэрэгжилт 129.4%				
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ						

№1.1.4.9		Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.9 арга хэмжээ: <b>"Барилгын материалын чанарт тавих лабораторийн хяналтыг өргөжүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх</b>					
	Төлөвлөлтийн уялдаа:	МУЗГҮАМХ-ийн 4.1.1.7				

Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Суурь түвшин	Хөтөлбөрийг үе шаттайгаар хэрэгжүүлсэн.				
	Шалгуур үзүүлэлт	Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажилын биелэлтийн хувь				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> Хөтөлбөрийг хэрэгжилт, үр дүнг тооцох <b>Жилийн эцэст:</b> Хөтөлбөрийг хэрэгжилтийн үр дүнг тайлагнах				
Арга хэмжээний хэрэгжилт	Хэрэгжилт	Нийслэлийн хэмжээнд Барилгын материалын 5-н итгэмжлэгдсэн лаборатори байдаг. Тус хөтөлбөр нь БХБЯ-ны харьяа Барилгын хөгжлийн төвийн лабораторид чиглэгдсэн ба 1,3 тэрбум төгрөгийн санхүүжилтээр Барилгын төмөр бетон эдлэл турших үйлдвэр болон 101 төрийн барилгын материал шалгах 65 нь төрлийн тоног төхөөрөмжийг суурьлуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Тус барилгын Мэргэжлийн хяналтын байгууллагаас 2020 онд улсын комисст хүлээн авч ажилласан.				
	Зарцуулсан хөрөнгө	-				
	Хүрсэн түвшин	101 төрлийн Барилгын материалыг Нийслэлдээ шинжлэх боломжтой болсоноор барилгын чанар дээшилнэ.				
Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үнэлгээ						

<b>№1.1.4.10</b>		<b>Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин</b>				
Арга хэмжээний нэр, дугаар	Гүйцэтгэлийн зорилтыг хэрэгжүүлэх 1.1.4.10 арга хэмжээ: 100 квт-аас дээш хүчин чадалтай халаалтын зууханд хяналт шалгалт хийж, магадлан итгэмжлжлэл хийнэ.					
	Төлөвлөлтийн уялдаа:	НЗДМХ-ийн 3.1.8, НЭЗНХҮЧ-ийн заалт				
Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хэрэгжих хугацаа	Улирал	1-р улирал	2-р улирал	3-р улирал	4-р улирал
	Шаардагдах хөрөнгө	-				
	Суурь түвшин	Байгууламж, тоо-180				
	Шалгуур үзүүлэлт	Байгууламж, тоо				
	Хүрэх түвшин	<b>Эхний хагас жилд:</b> 225 <b>Жилийн эцэст:</b> 451				
